

2011 оны 10 сарын 06-ны өдөр батлагдсан "Компаний тухай хууль"-ийн дагуу шинэчлэн найруулж 2012 оны 02 сарын 17-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлав.

## “ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙ ДҮРЭМ



### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Компанийн оноосон нэр:  
а) Бүрэн нэр: *“Дархан Нэхий” ХК*  
б) Товчилсон нэр: *“Дархан Нэхий” ХК*  
в) Компанийн оноосон нэр англиар: *“Darkhan” Nekhii JSC*  
г) Компаний гаргасан нээлттэй хувьцаа: *1 105 479 ширхэг*  
д) Хувьцааны нэрлэсэн үнэ: *100 төгрөг*  
е) Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ: *110'547'900 /нэг зуун арван сая таван зуун дөчин долоон мянга есөн зуун/ төгрөг*
2. Компанийн оршин байгаа хаяг  
а) Аймаг, хот: *Дархан – Уул аймаг*  
б) Сум, дүүрэг: *Дархан сум, Үйлдвэрийн дүүрэг*  
в) Хороо: *16-р баг*  
г) Гудамж талбай: *Үйлдвэрийн район*  
д) Шуудангийн хаяг: *Төв шуудан, ш/х № 901, Дархан сум, Дархан-Уул аймаг.*  
е) Харилцах утас : *70378499*  
ё) Факс: *70373149*  
ж) Электрон шуудан: *nekhii@yahoo.com*  
з) Web хуудас: *www.nekhii.mn*
3. “Дархан Нэхий” хувьцаат компани нь Компанийн тухай монгол улсын хуулийн дагуу зохион байгуулагдсан , бие даасан тайлан тэнцэлтэй, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх хуулийн этгээд байх бөгөөд хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь нийтэд чөлөөтэй арилжаалагдана.
4. Компанийн хувь нийлүүлэгчдийн бүртгэл, эзэмшиж байгаа хувьцааны бүртгэлийг 2012 оны 02- сарын 17–ны өдрийн байдлаар энэхүү дүрмийн салшгүй хэсэг болгон хавсаргав.
5. Компани нь орлого ашгаа арвижуулах замаар хувь нийлүүлэгчдийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх явдлыг үндсэн зорилгоо болгон үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна.
  - *Нэхий, арьс, шир, савхи, үслэг боловсруулалт,*
  - *Төрөл бүрийн арьс шир үслэг болон даавуун хувцас, жижиг эдлэлийн оёдол;*
  - *Гутлын үйлдвэрлэл;*
  - *Гадаад, дотоод худалдаа, үйлчилгээ;*
6. Компанийн үйл ажиллагаа явуулах хугацаа: *Хугацаа хязгаарлаагүй.*

7. Компани нь өөрийн салбар эсвэл төлөөлөгчийн газрыг бусад аймаг, хот, сум дүүрэг, хороонд ажиллуулна. Үүнийгээ хуульд заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлнэ.
8. Компани нь тодорхой мэргэжил тусгай зөвшөөрөл шаардагдах ажиллагаандаа холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авсны дараа улсын бүртгэлд бүртгүүлж, тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.
9. Компани нь улсын бүртгэлд орсон өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

#### **Хоёр. Компанийн үндсэн эрх**

1. Компани нь өөртөө барааны тэмдэг болон бэлэгдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас өөрийн нэр бүхий тэмдэг (тамга) хэрэглэнэ. Бэлэгдэл, барааны тэмдгийг Оюуны өмчийн газарт бүртгүүлж тэдгээрийг хэрэглэх эрхийг зөвхөн компани өөрөө эдэлнэ.
2. Компани өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар эсвэл бусадтай хамтран Монгол улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.
3. Компани өөрийн үйл ажиллагаагаа өргөтгөх, үйлчлүүлэгчид болон зах зээлдээ ойртох гэх мэт зорилгоор улс дотроо болон гадаадад салбар төлөөлөгчийн газар ажиллуулна.
4. Компанийн үндсэн ба туслах үйлдвэрлэл, үйлчилгээний ажлыг хэвийн явуулах зорилгоор мэргэжил чадвар сайтай дадлага туршлагатай хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдний ажиллах нөхцөл, цалин хөлс урамшууллын хэмжээг тогтоох.
5. Компани нь төрийн болон бусад аж ахуйн нэгж байгууллага түүнчлэн олон улсын холбогдох байгууллагад элсэн ашиг сонирхлоо хэрэгжүүлэхэд төлөөлөх, хамтран ажиллах зэргээр зохицуулалт хийнэ.
6. Компани өөрийн үйл ажиллагаатай холбоотой зарим зүйлийг хуулийн дагуу нууцлана.
7. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбогдох мэдээлэл цуглуулах, мөн ийм мэдээллийг үйлчлүүлэгч сонирхогчдод хүргэнэ.

#### **Гурав. Компанийн үндсэн үүрэг.**

1. Компани нь энэхүү дүрмийн 1-ийн 5-д заасан үйл ажиллагааг Монгол улсын хуульд заасны дагуу эрхлэх үүрэгтэй.
2. Компани нь Монгол улсын “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль, “Аудитын тухай” хуулийн дагуу нягтлан бодохын болон анхан шатны, дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөн санхүүгийн тайлан тэнцэл гарган баталгаажуулна.
3. Компани нь Монгол улсын албан татварын хуулиудын заалтыг хатуу мөрдөн татвараа өөрөө тодорхойлж сайн дураар төлнө.
4. Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ мэдээллийг цаг тухай бүр эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.
5. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын өмнө хуулиар өгөгдсөн үүргүүдийг биелүүлнэ.

- 49
6. Компани нь улс эх орны нийгэм эдийн засгийн хөгжилд бололцооны хэлбэрээр дэмжлэг тусалцаа үзүүлэн Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгаль орчныг хамгаалж ажиллана.
  7. Компани нь улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрөөс үйл ажиллагаагаа явуулна.

#### **Дөрөв. Компанийн үндсэн хариуцлага.**

1. Компани нь зөвхөн өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.
2. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын эрхийг зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээнэ.
3. Монгол улсын хуульд заасан бусад хариуцлагыг хүлээнэ.
4. ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, салбарын захирлууд болон нягтлан бодогч нар нь гэрээнд заагдсан хугацаанд эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд тэдгээр нь компанид өөрийн хууль бус үйл ажиллагаанаас учруулсан хохирлыг 100 хувь хариуцна.
5. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд “ Компанийн тухай “ хуулийн 85-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

#### **Тав. Хувьцаа эзэмшигчдийн эрх.**

1. Компанийн энгийн хувьцааг худалдан авч эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болно.
2. Компанийн хувь нийлүүлэгчдийн хурал зарлах үед ТУЗ-ээс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хувь нийлүүлэгчийн хуралд оролцож хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх эрхтэй.
3. ТУЗ-ээс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед эзэмшиж буй хувьцаанд оногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль, журамд заасан хугацаандаа олгохгүй бол алданги төлөхийг шаардах эрхтэй.
4. Компанийг татан буулгах үед “ Компанийн тухай” хуулийн 28-р зүйлд тогтоосон журмын дагуу үндсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх эрхтэй.
5. Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.
6. Хувь нийлүүлэгчдийн хурлаас доорхи асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувь нийлүүлэгч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг компани эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
  - Нийлэх, нэгдэх, хуваах болон ХХК болгож өөрчлөх шийдвэр гарсан;
  - Хэлцэл хийхийн өмнөх сүүлчийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг

- болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэргээр их хэмжээний хэлцэл хийсэн;
- Компанийн хувь нийлүүлэгчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийг шинэчилсэн найруулгыг баталсан.
7. Нэг хувь нийлүүлэгч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75 – аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
  8. Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа *Хувьцаа эзэмшигч* нь ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар “Компанийн хуулийн 66 дугаар зүйл”-д заасны дагуу саналаа эрхтэй.
  9. Хувьцаа эзэмшигч нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах үед “Компанийн тухай” хуулийн 65.6-т заасан баримт бичигтэй танилцах эрхтэй.
  10. Компанийн энгийн хувьцааны 1 болон түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтны буруугаар компани болон өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.
  11. Энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх, хувьцаа эзэмшигчийн нэрсийн жагсаалттай танилцах эрхтэй.

#### **Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн үүрэг**

1. Компанийн гэрээ, дүрмийн заалтыг хэлбэрэлтгүй сахих.
2. Компанийн үйл ажиллагаанд бололцоотой бүх талын дэмжлэг үзүүлэх.
3. Компанийн хувьцааг давуу эрхээр авах тухай саналаа хувьцааг худалдах шийдвэр гаргаснаас хойш ажлын 30 хоногийн дотор ирүүлэх.
4. Компанийн нууцыг чандлан хадгалах.
5. Хувь нийлүүлэгчдийн хоорондын харилцаанд чин шударга хандах.
6. Компанид хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа бол эрхэлсэн ажлаа үлгэр жишээ биелүүлэх.
7. Хувь нийлүүлэгч өөрийн буруугаас компанид хохирол учруулбал 100 хувь хариуцаж төлнө. Хохирол төлүүлэх тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр гарснаас хойш ажлын 12 хоногийн дотор төлбөрийг компанид төлнө.
8. Хувь нийлүүлэгч төлбөр төлөхөөс татгалзсан буюу зайлсхийсэн тохиолдолд хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр түүний ноогдох буюу тухайн жилд олгогдвол зохих ногдол ашгийн хэмжээг төлбөрийн дүнгийн хэмжээгээр хасч болно. Иймд боломжгүй тохиолдолд төлбөрийг шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.
9. Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны гуравны нэг хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээд нь худалдан авсан өдрөөсөө хойш ажлын 60 хоногийн дотор багтаан бусад хувь нийлүүлэгчдийн эзэмшиж байгаа хувьцааг уг хувьцааны сүүлийн 6 сарын зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал болгох үүрэгтэй. Энэ саналыг хуульд заасан журмын дагуу гаргаагүй бол уг

этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрх эдлэхгүй.

- 10. Компанийн нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшсэн этгээд ийнхүү өмчлөх эрх үүссэнээс хойш 3 хоногийн дотор компанид бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Ийнхүү мэдэгдэл илрүүлэх нь компанийн хувь нийлүүлэгчдийн хуралд асуудал хэлэлцүүлэхээр оруулах хуульд заасан эрхээ эдлэх баталгаа болно.

**Долоо. Хувьцаа эзэмшигчдийн хориглох зүйл, хүлээх хариуцлага**

- 1. Компанийн нэрийг хувийн ашиг сонирхолд ашиглахыг хориглоно.
- 2. Компанийн нэр хүнд, өмч хөрөнгөнд гэм хор учруулж болзошгүй ямарваа үйлдэл хийхийг хориглоно.
- 3. **Хувьцаа эзэмшигч** нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 4. Компанийн ТУЗ-ийн гишүүн, эрх бүхий албан тушаалтан болсон **Хувьцаа эзэмшигч** нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учруулсан эд хөрөнгийн хохирлыг өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.

**Найм. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа, бусад үнэт цаас, түүнийг гаргах, болон эргүүлэн авах**

- 1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө хувьцаанд хуваагдсан байх бөгөөд нэг бүр нь 100/нэг зуун/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1105479/нэг сая нэг зуун таван мянга дөрвөн зуун далан есөн/ ширхэг энгийн хувьцаа байна.
- 2. Нэмж гаргасан хувьцааг компанийн хувь нийлүүлэгчид тэргүүн ээлжинд худалдаж авах давуу эрхтэй. Энэ давуу эрхийг компанийн тухай хуулийн 38-р зүйлд заасан журмын дагуу хэрэгжүүлэх үүргийг ТУЗ хүлээнэ.
- 3. Компани давуу эрхийн хувьцаа гаргаж болно. Давуу эрхийн хувьцааны тоо, нэрлэсэн үнэ зориулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшигчдэд олгох давуу эрх зэргийг тухай бүр хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 4. Гаргасан хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болох бөгөөд энэ тохиолдолд хувьцааны төлбөрт хүлээн авч байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, оюуны өмчийн үнэлгээг эрх бүхий үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн ТУЗ тогтооно.
- 5. Үйл ажиллагааны зарим чиглэлээр охин компани байгуулан дүрмийн сангаа тэр хэмжээгээр хорогдуулж болно.
- 6. Компанид шинээр хувь нийлүүлэн оруулсан хөрөнгийн бүртгэл жагсаалтыг улсын бүртгэлийн материалд тухай бүр оруулж байна.
- 7. Энэхүү хөрөнгөнд тухайлбал үл хөдлөх хөрөнгийн хувьд үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ, хөдлөх хөрөнгөнд хөндлөнгийн байгууллага буюу хөрөнгийн үнэлгээний компанийн тайланг хавсаргаж баталгаажуулна.
- 8. Компани гаргасан энгийн хувьцаанаас гадна давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргаж болно.

9. Компани зарласан хувьцаанаас гүйлгээнд нэмж гаргах, бусад үнэт цаас гаргах шийдвэрийг ТУЗ гаргана. Үнэт цаас гаргах тухай шийдвэрт гаргах үнэт цаасны төрөл, тоо ширхэг, нэрлэсэн үнэ, үнийн дүн үнэт цаас гаргагч төвлөрүүлсэн хөрөнгийн зориулалт, үнэт цаасыг нийтэд эсвэл хаалттай захиалгаар худалдах, энгийн хувьцаанаас бусад үнэт цаас нь энгийн хувьцаанд хөрвөх эсэх, хөрвөх бол хөрвөх нөхцөл зэргийг заасан байна.
10. Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдахаар шийдвэрлэсэн бол үнэт цаасны хорооноос баталсан журмын дагуу бүртгүүлэх, хөрөнгийн биржид бүртгүүлэх, нийтэд сурталчлах андеррайтер болон зуучлах үнэт цаасны компанитай гэрээ байгуулан ажиллах асуудлыг гүйцэтгэх захирал хариуцан зохион байгуулна.
11. Компанийн зарласан хувьцаанаас ТУЗ-ийн шийдвэрээр гүйлгээнд нэмж гаргасан үед хувь нийлүүлэгчдэд тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх олгохын тулд хувьцаа худалдаж авах эрхийн бичгийг гаргана. Хувь нийлүүлэгчид хувьцаа худалдан авах давуу эрхийг гэрчлэх эрхийн бичгээ бүрэн болон хэсэгчлэн худалдаж болно. Хувьцаа худалдан авах эрхийн бичгийг биет бус үнэт цаасны хэлбэрээр гаргаж үнэт цаасны хороо, хөрөнгийн биржид бүртгүүлнэ.
12. Хувьцаа худалдан авах эрхийн бичгээ ашиглан хувьцаа худалдаж авах захиалга, хөрөнгийн биржийн төвлөрсөн хадгаламж дахь компанийн дансанд захиалсан хувьцааны үнийг төлсөн баримт зэргийг зар хүрснээс хойш 15 хоногийн дотор компанид ирүүлээгүй хувьцаа эзэмшигчдийн хувьцаа худалдаж авах эрхийн бичгийг ТУЗ-ийн шийдвэрээр нийтэд арилжаалж болно. Хувь нийлүүлэгч нь өөрт ногдох хувьцаа худалдаж авах эрхийн бичгээ бүрэн болон хэсэгчлэн бусдад худалдсан бол энэ тухай бичгээр худалдаж авах хувьцааны үнийг төвлөрсөн хадгаламж дахь компанийн дансанд төлсөн байна. Хувьцаа худалдаж авах эрхийн бичгийн хугацаа дуусмагц компанийн ТУЗ түүнийг хүчингүй болгох шийдвэр гаргаж үнэт цаасны хороо, хөрөнгийн биржид мэдэгдэж бүртгэлээс хасуулна.
13. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээс илүү хэмжээгээр 3 жил хүртэлх хугацаатай өрийн бичиг гаргах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. Шийдвэрт гаргах өрийн бичгийн тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, нөхцөл эргэж төлөгдөх хугацаа, эргүүлэн авах үнэ, энгийн хувьцаанд хөрвөх эсэхийг заасан байна.
14. Компанийн өөрийн хөрөнгийн дүнгээс илүү хэмжээгээр 3-аас дээш жилийн хугацаатай өрийн бичиг гаргах асуудлыг компанийн хувь нийлүүлэгчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Шийдвэрт энэ дүрмийн 5-ын 6-д заасан зүйлсийг мөн адил тусгана.
15. Компанийн тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцааг тогтоосон үнээр, заасан хугацаанд худалдан авах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно. Опционоор худалдаж авч болох энгийн хувьцаа нь гүйлгээнд байгаа нийт хувьцааны 25 хувиас бага бол опцион гаргах шийдвэрийг ТУЗ, түүнээс их бол хувь нийлүүлэгчдийн хурал гаргана. Шийдвэрт гаргах опционы тоо, нэгж опцион эзэмшигчийн худалдан авч болох хувьцааны тоо, хувьцаа худалдаж авах үнэ, опционы хүчинтэй байх хугацаа, опционы үнэ зэргийг заасан байна.

16. Компаниас гаргасан хувьцаанд хөрвөх үнэт цаасаар хөрвөх хувьцааны тоо, нийт гаргасан опционоор худалдах хувьцааны тоо, гүйлгээнд гаргасан хувьцааны тоо зэргийн нийлбэр нь нийт зарлагдсан хувьцааны тооноос илүү байж болохгүй.
17. Хувьцаа бусад үнэт цаасны үнийг “Компанийн тухай” хуулийн 55-р зүйлд заасны дагуу ТУЗ тогтооно.
18. Компаниас шинээр болон нэмж гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг мөнгө, үнэт цаас, эд хөрөнгийн хэлбэрээр хийж болно. Үнэт цаасны төлбөрт тооцох мөнгөн бус хөрөнгийн үнэлгээг уг хэлцэл хийхийг сонирхогч бус ТУЗ-ийн гишүүд санал нэгтэй тогтооно. Үнэлгээг тогтоохдоо мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэс болгоно.
19. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчтэй нь тохиролцсоны үндсэн дээр худалдан авч болно. Компани энгийн хувьцаанаас бусад цаасыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг худалдаж авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан байсан нийт хувьцааны дундажаас 25 хувиас илүүгүй байна.
20. Хувь нийлүүлэгчид компанид хувьцаагаа эргүүлэн худалдах эрхийг хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд энгийн хувьцааны 5- аас дээш хувийг эргүүлэн авах асуудлыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хуралд оролцогчдын дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
21. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг худалдаж авах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэртээ худалдаж авах үнэт цаасны төрөл, тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг заана.
22. Компани дараах нөхцөлд өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн авах шийдвэр гаргаж болно.
  - Эргүүлэн авах үүрэг бүхий энгийн хувьцааг эргүүлэн авсан;
  - Үнэт цаасаа эргүүлэн авсны дараа төлбөрийн чадвартай байх;
  - Компанийн өөрийн хөрөнгө нь гаргасан давуу хувьцааны эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээ зэргийн нийлбэрээс илүү байх.

### **Ес. Компанийн удирдлага түүний эрх хэмжээ**

#### *А. Хувьцаа эзэмшигчдийн хурал.*

1. Компанийн эрх барих дээд байгууллага бол хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
2. **Хувьцаа эзэмшигчдийн** хурал ээлжит болон ээлжит бус байна. Хурлын товыг хурал болохоос 30 хоногийн өмнө төвийн хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр зарлана.
3. **Хувьцаа эзэмшигчдийн** ээлжит хурлыг жил бүрийн 4-р сарын 1-ний дотор ТУЗ хуралдуулна. 3-р сарын 1 гэхэд ээлжит хурлыг зарлаагүй бол ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болж, хурал зарлан хуралдуулах эрх хяналтын зөвлөлд шилжинэ. Хяналтын зөвлөл бүрэн эрх шилжсэн хойш 15 хоногийн дотор ээлжит хурлыг зарлан хуралдуулна. Хяналтын зөвлөл энэ үүргээ биелүүлээгүй бол компанийн **хувьцаа эзэмшигчдийн аль** нэг нь хурал зарлах эрхтэй. Энэ тохиолдолд хувь нийлүүлэгчдийн хурал зарлах, хуралдуулах зардлыг компани гаргана.

4. **Хувьцаа эзэмшигчдийн** хурлыг ТУЗ-ийн дарга удирдан явуулна. Компанийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг эзэмшиж буй **Хувьцаа эзэмшигчдийн** саналаар хурлын даргыг сонгох асуудлыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож буй саналын эрхтэй гишүүдийн олонхийн саналаар сонгож болно.
5. Шаардлагатай тохиолдолд ТУЗ, эсхүл саналын эрхийн 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа **Хувьцаа эзэмшигчдийн** санаачлагаар ээлжит бус хурлыг “Компанийн тухай” хуульд заасан журмын дагуу зарлан хуралдуулж болно.
6. Дор дурьдсан асуудлыг зөвхөн **Хувьцаа эзэмшигчдийн** хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
  1. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, түүний шинэчилсэн найруулгыг батлах;
  2. Нийлэх, нэгдэх, хуваах, өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах, компаний хэлбэрийг өөрчлөх;
  3. Компанийн өрийг хувьцаагаар солих;
  4. Компанийг татан буулгах, татан буулгах комиссыг томилох;
  5. Хувьцааг хуваах, нэгтгэх;
  6. ТУЗ-ийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох;
  7. Хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг хувь нийлүүлэгчдэд эдлүүлэх эсэх;
  8. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан тэнцэл хэлэлцэх, ашиг хуваарилах талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
  9. ТУЗ-ээс хэлэлцүүлэхээр оруулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
  10. Компани өөрийн гаргасан нийт хувьцааны 5-аас илүү хувийг буцааж худалдаж авахыг зөвшөөрөх эсэх;
  11. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах;
  12. ТУЗ-ийн шийдвэрээр хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд;
7. Нэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход саналын эрхийн тоог тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааны тоог ТУЗ-д сонгогдох гишүүний тоогоор үржүүлж тодорхойлно.
8. Компанийн хурлын бүрэн эрхэд хамаарах бүх асуудлыг хуралд оролцогчдын саналын эрхийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
9. Хурлын тухай мэдээллийг нийтэд хүргэх, хуралд оролцох эрхтэй гишүүдийг тодруулах, санал авах ажиллагааг “Компанийн тухай” хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу явуулна.
10. **Хувьцаа эзэмшигчдийн** хурал хуралдуулах тухай шийдвэр гаргаж, хурлаар хэлэлцэх асуудлын товыг тогтоосноос хойш **Хувьцаа эзэмшигчдийн** хурлаар яаралтай хэлэлцэж шийдвэрлэх асуудал гарсан тохиолдолд хуралд оролцож буй хувь нийлүүлэгчдийн саналын дийлэнх олонхоор уг асуудлыг хэлэлцэхээр шийдвэр гаргаж болно.
11. Компанийн саналын эрхтэй хувьцааны 70-аас дээш хувийг эзэмшиж байгаа **Хувьцаа эзэмшигчдийн** хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно. Энд



заасан хувь хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж дахин хуралдах өдрийг товлож энэ тухай протокол үйлдэн ТУЗ-ийн дарга гарын үсэг зурна. Хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчилж болохгүй.

- 12. Саналын эрхийн 50-аас дээш хувийг эзэмшигчид оролцсоноор хойшлогдсон хурал хүчин төгөлдөр болно.
- 13. Хойшлогдсон хурлыг ажлын 20 хоногийн дотор хуралдуулна. Хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.
- 14. Хойшлогдсон хуралд бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй.
- 15. Хойшлогдсон хурал ажлын 20 хоногийн дотор хуралдаж чадахгүй бол шинээр хурал зарлаж хурал хүчин төгөлдөр болох ирцийг энэхүү зүйлийн 6.12-д зааснаар тогтоно.
- 16. Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураах замаар шийдвэрлэж болно. Эчнээ санал хураалтыг “Компанийн тухай” хуульд заасан журмын дагуу явуулна. Ээлжит хурлыг болон доорхи асуудлыг шийдвэрлэх хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно.
  - 1. Компанийн дүрмийг өөрчлөх, шинэчилсэн найруулгыг батлах;
  - 2. Компани нийлэх, нэгдэх, хуваах, татан буулгах, зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх.
- 17. Компанийн нийт гаргасан хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй **Хувьцаа эзэмшигч** нь өөрөө эчнээ санал хураалтын дүнг нэгтгэн гаргах тооллогын комисст үйл ажиллагааг ажиглагчаар оролцох эрхтэй.
- 18. **Хувьцаа эзэмшигчдийн** хурлын тэмдэглэлийг “Компанийн тухай” хуульд заасан журмын дагуу хөтөлж, баталгаажуулан хадгална.

**Б. Төлөөлөн удирдах зөвлөл**

- 1. ТУЗ нь энэ дүрмээр **Хувьцаа эзэмшигчдийн** хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
  - 1. Энэ дүрэмд заагаагүй үйл ажиллагааны чиглэлийг тогтоох;
  - 2. Хувь нийлүүлэгчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын бүртгэлийн өдөр, хурлын товыг тогтоох;
  - 3. Компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцааг нэмж гаргах;
  - 4. Хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;
  - 5. Компанийн тухай хуулийн 55-р зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
  - 6. Өөрийн гаргасан нийт энгийн хувьцааны 5 хүртэл хувийг болон бусад үнэт цаасыг худалдан авах, эргүүлэн авах;
  - 7. Компанийн гүйцэтгэх удирдлага, салбар хороодыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;
  - 8. Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал урамшууллын хэмжээг тогтоох;
  - 9. Компанийн аудиторыг сонгож, түүнтэй хийх гэрээний нөхцлийг тогтоох;
  - 10. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

11. Ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тогтоох;
  12. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журмыг батлах;
  13. Компанийн салбар төлөөлөгчийн газрыг байгуулах;
  14. Компанийг өөрчлөн байгуулах төсөл боловсруулж хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэх, шийдвэрийг хэрэгжүүлэх;
  15. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотойгоос бусад их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
  16. Сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
  17. Компаниас тусгаарлах тухай шийдвэр гаргах;
  18. Хувь нийлүүлэгчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал.
2. “Б” хэсгийн 1.5, 1.9, 1.16-д заасан асуудлыг шийдвэрлэхэд ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгнө. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь “Компаний тухай хууль”-ийн 79.1-р зүйлийн шаардлагыг хангасан байна.
  3. Компанийн ТУЗ нь 9/есөн/ гишүүнтэй байх ба түүний гуравны нэг нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийг хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаар 1/нэг/ жилийн хугацаатай сонгоно. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ.
  4. ТУЗ-ийн гишүүн нь удаан хугацаагаар үүргээ биелүүлж чадахгүй болсон эсхүл нас барсан тохиолдолд ТУЗ-өөс түр гишүүн томилж болно.
  5. Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг хууль дүрэмд заасан хугацаанд зарлаагүй бол 4-р сарын 1-ний өдрөөр ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болно.
  6. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос сонгоно.
  7. ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг гишүүдийн олонхийн саналаар сонгоно.
  8. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүрэг хүлээнэ.
  9. ТУЗ-ийн хурлыг улиралд 1 –ээс доошгүй удаа хуралдуулна. Шаардлагатай тохиолдолд нэмэлт хуралдаан хийж болно. ТУЗ – ийн шийдвэр нь тогтоол байх бөгөөд тогтоолд тухайн ТУЗ-ийн хурлын дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
  10. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнхи олонхиос доошгүй хувь нь оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнхи олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно. “Компанийн тухай” хууль болон энэ дүрмээр тухайн шийдвэрлэж байгаа асуудлаар ТУЗ-ийн зарим гишүүд санал өгөх эрхгүй байвал шийдвэрийг саналын эрхтэй ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. ТУЗ-ийн хуралд гишүүн бүр 1 саналын эрхтэй байна. ТУЗ-ийн дарга саналын давуу эрх эдлэхгүй.

#### ***В. Гүйцэтгэх удирдлага***

1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.
2. Гүйцэтгэх захирал нь энэ дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

3. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно.
4. Гүйцэтгэх захирал болон компанийн гүйцэтгэх удирдлагад ажиллаж буй эрх бүхий албан тушаалтнууд нь ТУЗ-ийн зөвшөөрөлгүй өөр компани, аж ахуйн нэгжийн гүйцэтгэх удирдлагад ажиллахыг хориглоно.
5. Гүйцэтгэх захирлын эрх үүрэг, хариуцлагын хэмжээ, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэргийг ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заана.
6. Энэ дүрэмд заасан ТУЗ-өөр батлуулах шаардлагатай их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцлээс компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой түүхий эд, материал, сав баглаа, боодол, сэлбэг хэрэгсэл, түлш шатахуун худалдан авах, бараа бэлэн бүтээгдэхүүн худалдах, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох хэлцэл үүнд хамаарахгүй) бусад хэлцэл хийх, компанийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах, эрх бүхий албан тушаалтныг ажилд томилох, чөлөөлөх, компанийн орон тоо, цалингийн хэмжээг тогтоох, компанийн ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг батлах, гэдэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг батлах зэрэг компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаагаа явуулна.

#### ***Г. Эрх бүхий албан тушаалтан***

1. ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, салбарын захирлууд болон нягтлан бодогч нар нь гэрээнд заагдсан хугацаанд эрх бүхий албан тушаалтан байна. /Хавсралт 1. Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын жагсаалт/
2. Компаний эрх бүхий албан тушаалтан нь “Компаний тухай хууль”-ийн 10 дугаар бүлгийн 84, 85-р зүйлд заасан шаардлагыг хангасан байх ба уг зүйлийн дагуу эрх эдэлж хариуцлага хүлээнэ.

#### **Арав. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл тайлан, ногдол ашгийн хувиарлалт**

1. Компани санхүүгийн жил, жил бүрийн 1-р сарын 1-нээс эхлэж, 12-р сарын 31-нд дуусгавар болно.
2. Компани нь санхүүгийн тайлангаа “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль, “Аудитын тухай” хууль болон бусад хуулийн дагуу баталгаажуулан үүний үндсэн дээр татварын багц хуулийн заалтад нийцүүлэн тогтоосон хугацаанд нь татвараа тодорхойлон төлж, татварын тайлан гаргаж тооцоо хийнэ. Санхүүгийн тайланг мөрдөж буй хууль, тогтоомжийн дагуу санхүү, татварын байгууллага, үнэт цаасны хороо, хөрөнгийн биржид хуулийн хугацаанд хүргүүлнэ.
3. Санхүүгийн тайланд дараах бүрдэл хэсгүүдийг заавал оруулна.
  - Баланс
  - Орлого үр дүнгийн тайлан
  - Мөнгөн гүйлгээний тайлан
  - Хуримтлагдсан ашгийн тайлан
  - Тайлангийн тайлбар, тодруулга, илтгэх хуудас

4. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг захирал хариуцна. Компанийн орон тоонд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ерөнхий нягтлан бодогч энэхүү хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.
5. Хяналт шалгалт, лавлагаа, түүх архивын зорилгоор дараах баримт бичгүүдийг хуульд заасан хугацаагаар хадгална.
  - Компанийн дүрэм түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд;
  - Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
  - Компанийн дотоод бичиг, баримт, материалууд;
  - Компанийн салбар болон төлөөлөгчийн газрын дүрэм, гэрээнүүд;
  - Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичгүүд;
  - Компанийн ерөнхий захирлын болон гүйцэтгэх захирлын тушаал шийдвэр, хурал зөвлөлгөөний тэмдэглэл;
  - Санхүү үйл ажиллагааны анхан шатны болон дэлгэрэнгүй бүртгэл, ня-бо бүртгэлийн баримт, бичиг, материалууд;
  - Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцэл түүнтэй холбогдох баримт, материалууд.
6. Компанийн нягтлан бодох бүртгэлийг хөтлөх нэгж нь төгрөг байх бөгөөд эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн орлого, зарлага, өр, авлагын гүйлгээг тухайн ажил гүйлгээ хийгдсэн валютаар болон төгрөгөөр бүртгэлд тусгана. Валютаар хийгдсэн ажил гүйлгээг төгрөгт шилжүүлэхдээ тухайн өдрийн Монгол банкны албан ханшийг баримтлана.
7. Компанийн аж ахуй санхүүгийн үйл ажиллагааг санхүүгийн тайлан, холбогдох анхан шатны нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтэд үндэслэн эрх бүхий татварын болон хөндлөнгийн хяналтын байгууллага шалгах эрхтэй бөгөөд компанийн эрх бүхий албан тушаалтан холбогдох баримт, маягтыг шаардлагын дагуу төлилуулах үүрэг хүлээнэ.
8. Компани Монгол улсын аль нэг болон хэд хэдэн банкинд төгрөгийн болон валютын данс нээх эрхтэй бөгөөд шинээр данс нээлгэсэн, хаалгасан тухай бүр Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж байна. Компани гадаадын банкинд валютын данс нээх бол энэ тухайгаа Монгол банк болон татварын албанд албан ёсоор мэдэгдэнэ.
9. Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурьдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна:
  1. Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
  2. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;
  3. Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.
10. Ногдол ашиг хувиарласны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувиарласны өмнөх хэмжээнээс 25-аас илүү хувиар багассан тохиолдолд ногдол ашгаа шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдэл хэмжээг бичгээр мэдэгдэнэ.
11. Ногдол ашиг хувиарлаагүй бол ТУЗ үүний шалтгааныг хувь нийлүүлэгчдийн хуралд тайлагнана.

- 12. Ногдол ашиг хувиарласны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээ, үйлдвэр хөгжүүлэх сан байгуулж болно. Санг байгуулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. Уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг гүйцэтгэх захирал боловсруулж ТУЗ-ийн хурлаар баталж мөрдөнө.

**Арван нэг. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт**

- 1. Аудитын тухай Монгол улсын хуульд заасны дагуу компанийн санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийх зорилгоор ТУЗ-ийн хурлаас сонгосон эрх бүхий аудитын байгууллагатай гэрээ байгуулан ажиллана.
- 2. Гэрээг ТУЗ-ийн хурлаар батлах бөгөөд гэрээнд аудиторын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заана.
- 3. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудиторын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна. Компанийн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулахын тулд ээлжит шалгалт хийнэ.
- 4. Ээлжит бус шалгалтыг ТУЗ-ийн хурлын шийдвэр, компанийн энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувь нийлүүлэгч, ТУЗ-ийн аудитийн хорооноос хэдийд ч хийж болно. Аль нэг хувь нийлүүлэгчийн захиалгаар хийгдсэнээс бусад шалгалтын хөлсийг компани хариуцаж төлнө. Хувь нийлүүлэгчийн захиалгаар хийгдсэн шалгалтын хөлсийг тухайн хувь нийлүүлэгч хариуцаж төлөх бөгөөд шалгалтын явцад эрх бүхий албан тушаалтан эсхүл хувь нийлүүлэгч компани, хувь нийлүүлэгч болон зээлдүүлэгчдэд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.
- 5. Компанийн эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримтыг танилцуулах үүрэгтэй.
- 6. Дараах этгээдийг компанийн аудиторроор сонгон ажиллуулахыг хориглоно:
  - 1. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтан, эрх бүхий тушаалтан;
  - 2. Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, компани болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд холбогдох бусад эд хөрөнгө буюу хөрөнгийн эрх эзэмшдэг бол;
  - 3. Компанитай аудитаас бусад асуудлаар гэрээ хэлцэл хийсэн бол.
- 7. Энэхүү дүрэмд заагаагүй бусад асуудлыг “Компаний тухай хууль”-ийн 94-р зүйлийн дагуу шийдвэрлэнэ.

**Арван хоёр. Компанийг өөрчлөн байгуулах**

- 1. Компанийн өөрчлөн байгуулах тухай ойлголтод компанийг хуваах бусад компанитай нийлэх, нэгдэх, тусгаарлах, хэлбэрийг өөрчлөх асуудлууд хамаарагдана.